

ДеФакто **ТОЙМ**

**“Оюу толгой” ХХК-ийг
тойрсон асуудлууд**

**Банкны тухай хууль
өөрчлөгдлөө**

**Тавантолгойн төмөр зам
төслийг хэрэгжүүлнэ**

Жагсаал цуглаан

VIII НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Ч.ХАШЧУЛУУН
Эдийн засгийн ухааны доктор

**МАНАЙ УЛСАД ТАТВАРЫН
МАШ ИХ ХЭМЖЭЭНИЙ
БОЛОМЖ БАЙНА.**

**ГУРАВХАН
НӨӨЦИЙГ НЬ
Л ХЭЛЬЕ**

V НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

**ХӨРӨНГӨӨ
НЭХЭМЖЛЭХ НЬ**

Нийтийн хөрөнгө болох нийслэлийн газруудыг хот, дүүргийн болон БОАЖЯ-ны үе үеийн удирдлага зохион байгуулалттайгаар үгсэн луйвардаж, ил далд зарж борлуулан баяжих хэрэгсэл болгосоор ирснийг...

III НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.01.24, №31

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

ХӨРӨНГӨӨ

НЭХЭМЖЛЭХ НЬ



Elegance is an attitude

Simon Baker
Simon Baker

LONGINES®



La Grande Classique de Longines

Хаяг: Наран Молл, 2-р давхар, Сөүлийн гудамж.

Утас: 99093122

Наран Центр, УИД-н баруун талд.



№ 415

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

Д.Жаргалсайханы Нийслэлийн газрын алба, газар зохион байгуулалттай холбоотойгоор зохион байгуулсан олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт уншсан илтгэлийн эх:

ХӨРӨНГӨӨ **НЭХЭМЖЛЭХ НЬ**

Нийтийн хөрөнгө болох нийслэлийн газруудыг хот, дүүргийн болон БОАЖЯ-ны үе үеийн удирдлага зохион байгуулалттайгаар үгсэн луйвардаж, ил далд зарж борлуулан баяжих хэрэгсэл болгосоор ирснийг Улаанбаатарын иргэд бид хичнээн удаан тэсэх ёстой юм бэ? Тэснэ тэснэ гэхэд тийм удаан, 20-30 жилээр тэсэж болох уу?

БОАЖЯ-ААС НЭХЭМЖЛЭХ НЬ

Газрын наймаа газар авч, Тусгай хамгаалалтын хууль гээчийг УИХ баталж, Туул, Тэрэлжийн сав газруудаас 4,000 га газрыг нь БОАЖЯ-ны сайд байсан МАХН-ын У.Барсболд гэгч зарж баяжсан. Богд уулын бүх амыг зарчихлаа гээд хэрэг нээж, шүүх ээлжит жүжиг тавиад л өнгөрсөн.

БОАЖЯ-ны үе үеийн сайд нар, тэдэнтэй холбоотой хүмүүс дархан цаазтай газрыг нүдлэн, хамгаалах нэрээр хотын газрыг эзэнгүй болгож, түүний дотор Яармагийн дэнжийг нууцаар борлуулсан юм. Хэн авсан нэрсийг нь гаргахаас яамныхан одоо болтол айсаар байна.

Эдүгээ Богд уулын аманд газрын жижиглэнгийн худалдаа ид өрнөж байна. Урд уулын бүх амыг хулгайлж хуваагаад, хашаа бариад, харуул, нохойгоор мануулж байна. Богд уулын ам болгон аугаа авлигын түүх болжээ.

Туул голоо, Яармагийн газраа эргүүлж өгөхийг УБ-ын иргэд монголын төрөөс шаардаж байна. Төр хулгайгаа зогсоо. Уг нь та нарыг хулгайл гэж биш, хамгаал гэж сонгодог юм аа.

НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГААС НЭХЭМЖЛЭХ НЬ

Хотын болон дүүргийн үе үеийн дарга нар нийслэлийн газрыг зувчуулж хөрөнгөждөг. Жишээ нь гэхэд л сургуулийн гаднах биеийн тамирын талбайнууд. Тухайлбал Орос 3-р сургуулийн хашаанд барьсан хоёр том орон сууцны хороолол.

Засаг дарга асан М.Энхболд 2003-2004 онд одоогийн Дунжингарав хорооллоос зүүн тийш Амгалан хүртэлх хотын цэвэр усны худагтай, 970 га зэлүүд газрыг ганцхан Мон-Уран компанид бөөндөж "бэлэглэснээр" газрын жижиглэнгийн худалдаа гаарсан юм.

Засаг дарга асан МАН-ын М.Энхболд, Ц.Батбаяр, Г.Мөнхбаяр нар Улаанбаатар Банк, Худалдаа Хөгжлийн Банкинд "онцгой хайртай" буюу бидний хөрөнгөөр босгосон банк, даатгал бүгдийг нь ганцхан этгээдэд өгчихсөн учир хотын төвийн, нийтийн эзэмшлийн, өндөр үнэлгээтэй олон газар, талбай,

цэцэрлэгийг энэ хоёр банкны мэдэлд "шилжүүлж" ирлээ.



Жишээ нь Нийслэлийн засаг дарга, Барилга, хот байгуулалтын сайд асан Г.Мөнхбаяр 2012 оны сонгуульд нам нь ялагдсаны дараа, хотын шинэ захиргаа байгуулагдахаас урьтаж наадмын өмнөх өдөр Сүхбаатарын талбайн урд хэсгийг өмнөх цэцэрлэгтэй нь хамт, УБ зочид буудлын өмнөх цэцэрлэг, Тагнуулын Ерөнхий Газрын өмнөх цэцэрлэг, Ю.Цэдэнбалын талбай ба цэцэрлэг, Академич Б.Ширэндэвийн хөшөөтэй Оюутны талбайг цэцэрлэгтэй нь Улаанбаатар Банкны эзэмшилд “бэлэглэхчээ” оджээ.

Нийслэлийн иргэд бид хотынхоо бүх талбай, цэцэрлэгт хүрээлэн, одоо бүр хотын захиргааны байшингаа хулгайд алджээ. Хотын одоогийн дарга Су. Батболд гуай байргүй болж буй учир Яармаг руу нүүхээ зарлав. Яармагт сул газар үлдээгүйг мэдэж л баймаар юм. Нүүх шалтгаан нь хотын захиргааны түүхэн байшинг Голомт Банкинд концессын гэрээгээр бариулж, ашиглуулах нөхцлөөр өмнөх дарга Э.Бат-Үүл “тендерээр” өгчихсөн байна. Тэгээд л тэр Баянхошуу руу нүүх тухай яриад байжээ. Энэ концессын гэрээ засаг солигдсоны дараа шүүхээр цуцлагдсан ч, саяхнаас хэрэг сэргэж, шүүх шийдвэрээ

ДҮГНЭЛТ

Нийтийн бүх өмч бүртгэлгүй, эзэнгүй байна. Тийм ч учраас хотын удирдлага юу дуртайгаа хийж чадаад байна. Нийтийн ба хамтын эзэмшлийн газар, өмч хөрөнгөө тодорхой болгоё, бүртгэе. Үндсэн хөрөнгө хэд байгаа, хэд нь татвар төлдөг, хичнээн төгрөг төлсөн, тэр нь юунд зарцуулагдсан юм бэ?

Энэ бүхэн хийгдэхгүй, хийх сонирхолгүй байгаа учир Улаанбаатар хот үндсэндээ дампуурлаа. Газрын үнэ, хахууль өсөхийн хэрээр орон сууцны үнэ тэнгэрт цойлж, УБ хотын гэр хороолол хэдэн уул давж тэлсээр

ГУРВАН ЧУХАЛ АЛХАМ

Үл хөдлөх хөрөнгийн салбарт гурван шинэчлэл хийх шаардлагатай байна.

Юуны өмнө хотын аль хэсэгт иргэд амьдарч, оршин суурьших, ногоон байгууламж барих, хаана нь үйлдвэр, үйлчилгээний газрууд байхыг бүсчлэн зааглаж, ялган салгаж хуульчилж, амьдарч, ажиллах нийтийг хамарсан тодорхой стандарт тавьж, сахиулах шаардлагатай байна.

Дараа нь үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг бодитой тогтоож, татварыг нь хурааж, орлогынх нь талыг тухайн үл хөдлөх хөрөнгийн байршлын дэд бүтцийг

дахин харж үзэх болсон тул хотын захиргаа нүүх гэж байна.

ХХБ болон Голомт Банк нийслэлийн иргэдийн хөрөнгийг үе үеийн, хоёр намын засаг дарга нартай хуйвалдан завшихаас гадна, хотын маань түүхийг баллуурдаж байна. ХХБ Хүүхдийн номын сангийн түүхэн барилгыг буулгаад шил бетон хийцтэй, дөрвөлжин цагаан хайрцаг босгосон. Өмнөх байшингаа буулгачихаад, шинэ цамхаг барихдаа Занабазарын музей руу өнгийх болсныг музейн өмнөх захирал нь халаглан учирлаж байлаа.

Одоо Голомт Банк Хотын захиргааны түүхэн дурсгалт, 1948 онд барьсан Алтай Зочид буудал, дараа нь хотын захиргааны байр болсон байшинг, өөрсдийнхөө 20-иод жилийн өмнө барьж хотын захиргааг хахуульдсан биеийн тамирын заалын хамт буулгаад, оронд нь бас нэг шилэн хайрцаг босгож гурав, гурван давхраар нь хувааж эзэмших “концесс” сэргэж байна.

Хот бол яг хүн шиг өөрийн түүх намтартай, нүүр царайтай “амьд бие” юм. Ядаж гадаад хийцийг нь үлдээх талаар хэн, юу хийж байгаа юм бэ?

хорт утаандаа живж, Улаанбаатар “Утаанбаатар” болчихоод байна. Хотоо тойрсон хогон дээр “хүн сүрэг” бий болов. Улаанбаатар хотын дүр төрхийг дайсан ч ингэж зэрэмдэглэж чадахгүй байсан.

Тэр сайд ч, хотын захирагч нар ч, төр барьж ирсэн МАХН, МАН, АН аль нь ч, хэн нь ч дээрх бүх авлигын хэргүүдэд хариуцлага хүлээгээгүй, харин ч гэмт этгээдүүд цэцэглэн хөгжсөөр байна.

арчлах, шинэчлэхэд ашиглаж, үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх.

Гурав дахь нь бүх үл хөдлөх хөрөнгийн талбай, хэний өмч болох, ямар үнэлгээтэй, ямар татвар төлсөн, тухайн газар дээр ямар барилга байгууламж хэн барьж байгаа, хэзээ баригдаж дуусах гэх мэт холбогдох бүхий л мэдээллийг олон нийтэд хүргэж чадах вебсайт (public domain) бий болгох шаардлагатай байна.

2018.01.24



Ч.ХАШЧУЛУУН

Эдийн засгийн ухааны доктор

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

МАНАЙ УЛСАД ТАТВАРЫН МАШ ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОМЖ БАЙНА. ГУРАВХАН НӨӨЦИЙГ НЬ Л ХЭЛЬЕ

Эдийн засгийн ухааны доктор Чулуундоржийн Хашчулуун нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн анхны төсөл, Концесс, Инновацийн хууль, Хөгжлийн банкны хууль, Төсвийн хуулийн зарим хэсгийг боловсруулж батлуулах ажлыг удирдаж байсан. Ерөнхий сайдын дэргэдэх Хөгжлийн бодлогын зөвлөл, Ерөнхийлөгчийн дэргэдэх Эдийн засагч нарын зөвлөл, МУ-ын үндэсний хөгжлийн цогц бодлогын ажлын бүлэг гэх мэт олон газар ажилласан туршлагатай ба МУИС-ийн Эрдмийн зөвлөл, ТУЗ-ийн гишүүн юм.

Д.Ж: Сайн байна уу, Хашчулуун доктор. Хоёулаа өнөөдөр Монгол улсын эдийн засгийн тухай хэдэн үг солимоор байна. Ялангуяа бид 27 жилийн өмнө, зах зээлийн эдийн засаг руу шилжлээ л гэсэн. Тэгээд одоо шилжилт маань хаана явааг, ерөнхийдөө бол төөрчихсөн байгаа. Яагаад гэвэл төрийн биш хувийн хэвшил рүү явна гэсэн чинь одоо төр нь томроод байна. Энэ агуулга дотор хоёулаа өнөөдөр эдийн засгийн байдлыг, өрөнд орсон байдлыг, татвар нэмээд байгаа байдлыг. Хэзээ энэ бүхэн зогсох юм? Хэзээ татвараа нэмэхээ болих юм? Хэзээ өрнөөсөө гарах юм? Энэ талаар та макро эдийн засагчийн хувьд ярьж өгөхгүй юу.

Ч.Х: Ойлголоо. Ерөнхийдөө бол манай эдийн засгийн хувьд сүүлийн 10 жил их эрчимтэй өссөн. Том болсон нь үнэн байгаа. Статистикийн бүх тоогоор тэгж гарч байгаа. Тодорхой хэмжээгээр бас ядуурал буурч байсан. Ийм амжилтанд хүрсэн түүх байгаа. Тухайн үедээ эдийн засгийн өсөлт бол дэлхийд хамгийн өндөр гэж тооцогдож байсан. Ер нь бол бодит эдийн засгийн өсөлтүүд байсан тул ямар нэгэн байдлаар дутуу үнэлж болохгүй. Тэгэхдээ манай эдийн засгийн байдал хүнд байгаа нь юуны өмнө уул уурхайн салбар сайн хөгжиж чадахгүй байгаатай холбоотой гэж үзэж байгаа. Энэ юунаас болж байна вэ гэвэл бидний ярьдгаар төрийн оролцоо буруу талаар орж ирлээ гэж хэлж болох юм даа. Ер нь бол 2006 он хүртэл манай уул уурхайн салбар харьцангуй төрийн оролцоо багатай салбар байсан юм. Тэгээд 2006, 2007 онд стратегийн орд гэх ойлголтыг бий болгож эхэлсэн. Үүний дагуу бол манай томоохон ордууд дээр заавал төрийн оролцоо байх ёстой гэсэн ойлголт өгч эхэлсэн. Уг нь бол тийм байгаагүй юм. Яг зах зээлийн ном журмаараа л явж байсан. За тэгээд төрийн оролцоо бий боллоо. Манай улсад төрийн оролцоо гэдэг нь ялсан нам ч юмуу улс төрийн гарт орж байна гэсэн үг л дээ. Тэр маань өөрөө ашиг сонирхол нь илүү богино хугацааных. Тэгээд төрийн оролцоо анх үүслээ гээд Эрдэнэс МГЛ гээд компанийг байгуулсан.

За тэгээд үүний дагуу баахан төрийн мэдлийн уурхай, компаниудыг үүсгэж эхэлсэн. 2015 он гэхэд их олон болсон. Бүр холдинг болгоод томроод. Уг нь бол уул уурхайн салбарын л компани шүү дээ, төрийн. Тэгээд одоо ийм байдал үүссэн. Хамгийн аюултай нь зарим салбарт төдийлөн мэдэгддэггүй боловч жишээлбэл нүүрсний салбарт экспортлогч нь төр өөрөө болчихож байгаа юм. Тэгээд төр экспорт хийхдээ маш бага үнээр өгсөн. Их буруу гэрээнүүдийг хийсэн. Салбараа ерөөсөө "алсан" гэж хэлж болно.

Д.Ж: Тэгэхээр одоо яаж гарах вэ?

Ч.Х: Эндээс гарах цорын ганц арга нь улсын том компаниудыг аажмаар хувьчлах. Үгүй хийх. За бүр болохгүй байлаа гэхэд хувьцааг нь ч юмуу хүмүүст эзэмшүүлэх арга бий л дээ. Манай нөхцөлд бол үүнийг хийхдээ аль болох хүмүүст таалагдахын төлөө хийж байгаа. Компанийн үр ашгаа бодохгүй байгаа. Ихээхэн эмгэнэлтэй. Одоо ингээд харьцуулж болно л доо. Адилхан Таван Толгой гээд нэг орд байна. Тэрийг одоогийн байдлаар 3 компани хуваагаад хэрэглэж байгаа. За нэг нь болохоор Ухаа Худаг дээр хувийн компани байгаа. Энержи Ресурс гээд. За тэр нь бол өөрийнхөө баяжуулах үйлдвэрийг барьчихсан. Цахилгаан станцаа барьчихсан. Хотхоноо барьчихсан гээд яваад болоод байгаа юм. Байдал адилхан бүгдэд нь хүнд бууж байгаа ч гэсэн. За жижиг Таван Толгой буюу орон нутгийн эзэмшлийн нэг уурхай байгаа. Тэр ямар ч байсан муу ч сайн ч гэсэн ажиллаад л. Өмнөговийн иргэдэд жил бүрийн цагаан сараар бараг мөнгө өгч байгаа байх. За улсын мэдлийн компанийг аваад үзэхээр Эрдэнэс Таван Толгой гэж асар том компани бий. Үнээ тогтоохдоо дандаа зах зээлийн ханшаас доогуур. Гаргахдаа хамгийн сайн чанарын нүүрсээ сорчилж гаргадаг.

Д.Ж: Өөрсдөө баахан алдагдалтай ажиллаад төсвөө "будaa" болгочихоод одоо татвараа нэмсэн. Тансаглахыг нь төр тансаглалаа. Одоо бид нар нийлээд төлбөрийг нь төлж байгаа юм. Энэ татварыг яаж

бууруулах вэ? Боломж бий юу?

Ч.Х: Миний бодлоор бол анхнаасаа өсгөх нь буруу байсан байх. За ингээд аваад үзэхээр нэмэгдэж байгаа орлого нь тавин хэдэн тэрбум төгрөг л байгаа. Гэтэл манай улсад татварын маш их хэмжээний боломж байна. Би одоо гуравхан нөөцийг л хэлье гэж бодож байна. Нэг нь түүхий нүүрсний экспортын татвар. Жилд манай улс 30 орчим сая тонныг экспорт буюу нүүрсээр хийж байгаа. Тэр бол бидний ярьдгаар ямар ч боловсруулаагүй түүхий нүүрс байгаа. Тэрийг дийлэнх нь миний дээр хэлснээр төрийн өмчийн компани гаргаж байгаа. Зах зээлийн үнээс доогуур гаргаж байгаа. Тэгэхээр ядаж нэг тонн дээр 10 орчим долларын татвар ногдуулж болно. Ингэж үзэх юм бол зөвхөн тэр экспортын татвараар 300 орчим сая долларын татвар авах боломж байна. Төгрөгийн ханшаар бодох юм бол 800 тэрбум төгрөг.

Д.Ж: За хоёрдугаарт?

Ч.Х: Хоёрдугаарт Монгол улс 65 сая малтай. Малын дийлэнх нь мянгат малчдын гарт байгаа. Түүнээс бүгдээрээ тэгш эзэмшиж байгаа зүйл байхгүй. Саяхан гарсан судалгааг харахад малчдын дотор ядуу малчид их болчихсон байна. Тэгэхээр 65 сая малын илүүдлээс нь тодорхой хэмжээний татвар авахад ямар ч асуудал байхгүй байгаа юм. 2008 он хүртэл тийм татварыг Монгол улс хураадаг байсан. Болоод л байдаг байсан. Тэр татвар чинь ямар хэрэгтэй юм бэ гэхээр орлого нь орон нутгийн хөгжилдөө зориулагддаг.

Д.Ж: За гуравт нь?

Ч.Х: Гуравт нь манай улс үйлчилгээний эдийн засагтай буюу ченж эдийн засагтай гэж хэлж болох юм. Яахав энд тэндээс авчраад зардаг. Тэгээд тэрийгээ тодорхой хэмжээгээр татварт оруулах гэж их хичээсэн. Том худалдааны сүлжээ, борлуулалтынхан бол орсон. Гэтэл хүн амын дийлэнх нь орлого багатай учраас том том захуудаас, гудамжнаас, гар дээрээс, за тэгээд нууцаар, таньдаг хүмүүсийн хооронд. Орон сууцны ченжүүд гэж байна. Байрныхан, махныхан, бүх төрлийнх. Энэ нь өөрөө эргэлт маш өндөр гэж байгаа юм. Хэмжээг нь сайн мэдэхгүй байна гэж байгаа юм. Ерөөсөө судалж гаргаагүй.

Д.Ж: Хоёулаа одоо түлшний талаар яримаар байна. Үнэ зохицуулна гээд гаж тогтолцоо байна. Үүнийг та яаж харж байна?

Ч.Х: Эхлээд үнэ яагаад өссөн бэ гэдгийг ярих нь зөв байх. Ерөнхийдөө бол 2016 оноос хойш манай төгрөг 2000 байснаа ханш нь 2400 болтлоо уналаа. Дээрээс нь хоёр удаа ногдуулдаг тусгай татвар нэмэгдлээ. Сүүлийн үед Оросын үнэ харьцангуй тогтвортой ч гэсэн нефтийн үнэ дэлхийн зах зээл дээр хамгийн өндөр түвшиндээ хүрлээ. Ингээд доороосоо түлхдэг үнийн хүчин зүйлсийн

бүх юм бүрдчихсэн байгаа. Гэтэл нөгөө талаасаа аваад үзэхээр төрийг үнээ барьчихаар энэ үнээр л зарж болно гээд байгаа. Тэгэхээр энэ төрийн хүсээд байгаа үнэ компаниуд хангаж чадах үнэ хоёрын хооронд асар их алдагдал үүслээ. Ерөнхийдөө бол 3 сар алдагдалтай байна. Үүнийг янз бүрийн байдлаар ашиглаж байна л даа, хараад байхад. Жишээлбэл нэг хэсэг нь гадаадын компаниудыг олноор оруулчих юм бол асуудал шийдэгдэнэ гэж ярьж байгаа. Нөгөө хэсэг нь дотоодын компанийг дампууруулчихвал сайхан болно гэж ярьж байна. Гэтэл яг орон нутаг, улсаа нефть шатахуунаар бид нар хангаж л таараа. Энэ бол зайлшгүй байх ёстой. Хоёрдугаарт, зарлага нь орлогоосоо хэтрээд байвал төрд амархан хоёр шийдэл байна. Нэг нь онцгой татварыг авахгүй байж болно. Ер нь бол эцсийн эцэст эргээд л үнээ хямд байлгахыг хүсээд байгаа бол татвараа нэмэхээ болих хэрэгтэй. Хоёрдахь нь чөлөөтэй тавьж болно. За ингээд зах зээлийн жамаараа бүрдэг ээ. Дэлхийд үнэтэй байдаг юм бол монголд үнэтэй болог. Дэлхийд хямдхан болдог юм бол монголдоо хямдхан болог. Тэр болгоныг дундаас нь ашиг унагаах гээд байдгаа болилоо гээд салж болно л доо. Уг нь тэгж л 1990-ээд оны эхээр карттай, аймшигтай хомсдолтой, зодоонтой, талх авах гэж л цаг дугаарладаг эдийн засгаас салж чадсан шүү дээ.

Д.Ж: Ипотекийн зээл гээд боломжгүй юм эхэлчихээд хамаагүй хямдхан үнээр тодорхой хүмүүст нь байр өгнө гээд байгаа. Одоо бүгдийг нь төсөв рүү шилжүүлнэ гэнэ л дээ. Энэ 5%-ийн ипотекийн зээл гэж байх боломжгүй ээ гэж би эхнээсээ ярьж л байсан. Та яаж харж байна вэ?

Ч.Х: Уг нь бол Сингапур, Хонг Конг зэрэг улсууд хүн амаа орон сууцжуулахын тулд өөрсдийнх нь хуримтлалыг ашигладаг юм. Тэрэнд нь тааруулаад байр орон сууцыг нь барьж өгдөг юм.

Д.Ж: Яг тааруулаад. Бүр нэг өрөөтэй түрээсийн байр хүртэл өгсөн байгаа юм чинь. Тэгээд орон сууцтай болгоод шавар шавхайнаас нь салгачихсан байдаг.

Ч.Х: Тийм. Ер нь бол энэ дотроос хамгийн эрүүл тогтолцоо бол түрээсийн байр байгаа юм. Яагаад түрээсийн байр вэ гэхээр орон сууцанд орох гэж байгаа хүнд мөнгө байхгүй бол танд сонголт байна аа гээд. Япон, Америк том улсуудад байр эзэмшиж байгаа хүн бараг байхгүй. Бүгдээрээ түрээсээр амьдардаг шүү дээ.

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/ch-khashchuluun-khashchuluun-chuluundorj> холбоосоор үзнэ үү.

Татгалзахын аргагүй САНАЛ

FORD EXPLORER | RANGE ROVER | JAGUAR F-PACE

ШАТАХУУНЫ ЭРХ | ӨВЛИЙН ДУГУЙ

АЯЛАЛЫН ЭРХ | СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ

Холбоо барих: 99118301, 99106507, 99118375
www.waa.mn

WAGNER ASIA AUTOMOTIVE LLC



Дэлгэрийн УЯНГА

Өмгөөлөгч, хууль зүйн доктор

ИХ ХУРЛЫГ ТАРААХ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЛҮНДЭН БАРЦАД АРИЛГАХ УУ? БАЛАГ ТАРИХ УУ?

Онцгой байдал тогтоож, “Утаанбаатар”-ын агаарын гамшгийг цагаан сар гэхэд бууруулахгүй бол Их Хурлыг өөрийг нь тараах тухай ширүүн лүндэнг шинэ Ерөнхийлөгч шинэ он гармагц буулгасан, Д. Жаргалсайхан, [Дефакто Газет №29](#). Энэхүү нийтлэлээр УИХ-ыг тараах Ерөнхийлөгчийн эрх мэдэлтэй холбоотой хуулийн заалтыг товч танилцуулж, өөрийн үзэл бодлоо илэрхийлье.

ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Үндсэн Хууль, Улсын Их Хурлын тухай хуулиудад холбогдох алхмуудыг нарийн зааж өгчээ. Улсын Их Хурлын сонгуулийг ээлжит хугацаанаас өмнө хийх боломжийг нээж, УИХ өөрөө тарах санаачлагыг Ерөнхийлөгч гаргаж болно. Үүний тулд Ерөнхийлөгч эхлээд УИХ-ын даргатай зөвшилцөнө. УИХ-ын дарга санаачлагыг дэмжвэл УИХ-ыг хугацаанаас өмнө тараах тогтоолын төслийг УИХ-д өргөн барина. Тогтоолын төслийг УИХ-ын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол УИХ өөрөө тарах тухай шийдвэр гарна. УИХ тарах үндэслэл нь УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй бодит нөхцөл байдал үүссэн байх явдал юм.

ҮЗЭЛ БОДОЛ

Монгол Ардын Нам нь УИХ-ын нийт 76 суудлаас үнэмлэхүй олонх буюу 65 суудлыг авч Улсын Их Хурал, Засгийн газрыг 2016 оны 6-р сараас эхэлж хянаж байгаа билээ. Төрийн эрх мэдлийн харилцаанд 2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль өөрчлөлт оруулсан. Хэдийгээр Ардчилсан нам нь УИХ-д ердөө 9 суудалтай боловч тус намын нэр дэвшигч Х. Баттулга Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсан. Монгол Улсад Ерөнхийлөгч нь Засгийн газрын үйл ажиллагаанд чиглэл өгч, үйл ажиллагаанд нь жинтэй нөлөөлдөг боловч Засгийн Газрыг тэргүүлдэггүй, үйл ажиллагааных нь төлөө Их Хурал болон сонгогчдын өмнө хариуцлага хүлээдэггүй. Чингэхдээ Ерөнхийлөгч нь Шүүх засаглалын дефакто дарга бөгөөд прокурор, авлигатай тэмцэх, батлан хамгаалах, тагнуулын байгууллагуудад холбогдох эрх мэдэлтэй.

Ерөнхийлөгч нь ард түмнээс шууд сонгогддог. Тэрээр монголын бүх ард түмнээс шууд эрх олж авсан энэ улсын цорын ганц удирдагч юм. Засгийн Газрын тэргүүн болох Ерөнхий сайд нь ард түмнээс шууд бус, харин Их Хурлаас томилогддог тул Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдтай харьцуулбал бүх ард түмний дэмжлэгийг авах илүү их чадвартай, ард түмний дунд илүү их нөлөөтэй. Ард түмнээс шууд сонгогдож олж авсан энэхүү бодит эрх мэдэл нь шүүх засаглал болон бусад холбогдох хууль хэрэгжүүлэх, батлан хамгаалах эрх мэдлүүдтэй хослож, Ерөнхийлөгчид өөрийн сонгуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, улс төрийн ашиг

сонирхлоо Засгийн газар болон УИХ-тай харилцахдаа гүйцэлдүүлэх боломжтой хэлэлцээний хүчтэй талын байр суурийг өгдөг.

Ерөнхийлөгч УИХ-ыг тараахыг шаардсан шаардлага нь монголын ардчиллын хувьд шинэ практик. Энэ нь одоогийн тогтолцоонд эрсдэл өндөртэй алхам юм. Ерөнхийлөгчийн өөрийнх нь нам УИХ-д есхөн суудалтай тул тэрээр УИХ-ын үнэмлэхүй олонхыг хянаж байгаа МАН-тай харилцахдаа бодит амьдрал дээр хүчин мөхөсдөж байгаагийн илрэл байж болох юм. МАН УИХ-ын үнэмлэхүй олонхыг хянаж байгаа энэ үед Ерөнхийлөгч хуулийн дагуу УИХ-ыг тараах санаачлага гаргах эрхтэй ч тэрээр УИХ-ын дэмжлэгийг авч чадахгүй нь ойлгомжтой юм.

Ерөнхийлөгчийн шаардлага нь хуралдаа ирдэггүй, ажлаа хийдэггүй гэж шүүмжлүүлдэг УИХ-ын барцдыг арилгах бус харин энэ улсад балаг тарих эрсдэлтэй юм. Бүх ард түмнээс шууд сонгогдсон удирдагчийн үг, үйлдэл бүр нь жирийн ардын оюун санаанд хүчтэй ул мөрөө үлдээдэг. УИХ-ыг тараах тухай Ерөнхийлөгч энэ цагт дуугарч байгаа нь ард иргэд, үүний дотор Ерөнхийлөгчийн шүтэн бишрэгчид, халуун дэмжигчдийг УИХ-ын эсрэг турхирах сэтгэл зүйн хөрсийг тавьж байна.

МУ бол ардчилсан Үндсэн хуультай улс. Энэхүү ардчилсан Үндсэн хууль болон дэлхий даяарх ардчиллын нийтлэг загварын дагуу “Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй” бодит нөхцөл байдал бий болсон бол УИХ өөрөө тарах шийдвэр гаргах үйл явцыг эхлүүлэх учиртай. Үүнд УИХ-д олонх бүрэлдэх боломжгүй болсон үеийг ойлгоно. УИХ-д үнэмлэхүй олонх байгаа үед Ерөнхийлөгч УИХ-ыг тараах тухай мэдэгдэл хийж байгаа нь төрийн барцдыг арилгах бус, түмэн олны эв нэгдэлд балаг тарих эрсдэлтэй.

Алс ирээдүйдээ олонх бүрэлдүүлэх чадвартай УИХ-ын эсрэг бүх ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгч ард иргэдийн нэг хэсгийн “цусыг хөөргөх” боломжтой энэ мэт мэдэгдэл хийх боломжгүй байхаар тогтолцоогоо шинэчлэх шаардлагатай, Д.Уянга, [Дефакто Газет № 10](#). УИХ-ын олонхын дэмжлэгийг авах бодит боломжгүй, УИХ-ын цөөнх болох намын хүнд шүүх эрх мэдэл, прокурор, авлигатай тэмцэх, батлан хамгаалах, тагнуулын албанд холбогдох эрх мэдэл хуулиар өгч байгаа нь ХБНГУ-ын өнгөрсөн түүхийг сануулах нэг шалтгаан болж байна. Засгийн газраа байн байн унагааж, улмаар эмх замбараагүй байдал нь дарангуйллаар эргэж, ардчилсан Үндсэн хууль тогтолцоо нь нуран унасан Германы Ваймарын Үндсэн хуулийн нэг алдаа нь Ерөнхийлөгч, Канцлер, Парламентын “гурвалжин тогтолцоо” байсан юм.



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2018.01.21-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://fargaldefacto.com/category/12>

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК-ИЙГ ТОЙРСОН АСУУДЛУУД



“Оюу толгой” ХХК-ийн гадаад ажилтнууд визний асуудалд орж, мөн Татварын Ерөнхий газраас 155 сая а м . д о л л а р ы н т о р г у у л ь ногдуулжээ. Уг торгуулийг 2013-2015 оны хооронд төлсөн татварт

аудит хийж, зөрчил илрүүлсэн учраас ногдуулсан байна.

Энэ асуудлыг би улс төрийн ямар нэг онцгой шалтгаантай гэж бодохгүй байна. Харин цаг хугацааны хувьд л давхацсан байх. “Оюу толгой” ХХК-нд шалгалт хийхэд түүний гүйцэтгэх компани болох Хоппман Инженерингийн 40 орчим Австрали, Канад, АНУ-ын иргэд гурван сарын хугацаатай жуулчны визээр орж ирсэн ч ажиллаж байгааг нь илрүүлж, түүнийг нь зургаар баталгаажуулан прокурорын газраас зөвшөөрөл авч, хуулийн дагуу хэргийг шийдвэрлэхээр явсан юм билээ. Уг нь бол гадаадын иргэн ажиллуулахаар бол Уул уурхай, хүнд үйлдвэрийн ямаар дамжин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлагаас зөвшөөрөл авах ёстой байдаг. Ер нь аль ч улсын иргэн тухайн улсын хууль журмыг дагахгүй, зөрчөөд байвал буцаагаад явуулдаг шүү дээ. Тэгэхээр энэ

асуудал дээр онцгойлоод улс төржөөд байх зүйл байхгүй гэж бодож байна. Гадаадын иргэдийг ажиллуулж байгаа компаниуд хууль журмынхаа дагуу л ажиллах хэрэгтэй. 2016 онд Европт хамгийн их баривчлагдсан хүмүүс нь хүн амын тоонд харьцуулахад монголчууд байсан байна. Тэр дундаа хамгийн их монголчуудыг барьсан буюу 200 гаруй хүн баривчилсан газар Франц улс байжээ. Харин 2017 онд Нидерландад 200 гаруй ба Бельгид 125 монголчуудыг баривчилсан байна. Тэгэхээр хуулийн дагуу тэгш эрхтэйгээр бүх зүйл явагдаж байна гэж харж байна.

2015 онд “Оюу толгой” ХХК-ийн татвартай холбоотой том хэрэг гарч байсан. 2010, 2012 онуудад татварын шалгалт хийж 127 сая ам.долларын торгууль ногдуулж байсан ба шалтгааныг 2014 онд шалгаж 2015 онд ярилцсан байдаг. Ярилцаад борлуулалтын орлогын тооцооны асуудал байна гэж 2015 онд тогтож байсан. Дубайн гэрээгээр энэ 127 сая ам.долларыг 30 сая ам.доллар болгохоор тохиролцоод хаасан. Харин өнгөрсөн долоо хоногт зарласан шалгалтын мэдээлэл бол 2013, 2014 оны асуудал юм байна л даа. Гэтэл үүнд 2015 онд хоорондоо тохирсон аргачлал нь ороогүй байна. Учир нь 2015 онд аргачлалаа тогтсон байхад тайлан нь 2013, 2014 оных байсан ба үүнээс болж 155 сая ам.долларын торгууль тавьжээ. Энэ шалгалт 2015 оноос өмнөхийг шалгаж байгаа учраас ийм асуудал гарсан гэж ойлгож байна. Цаашид ийм явдал гарахгүй гэж найдаж байгаа. Ер нь манай татварын хууль бага зэрэг чанга, олон улсын хуулиудтай зөрдөг ч тохиолдол байдаг.

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ ӨӨРЧЛӨГДЛӨӨ

2018 оны нэгдүгээр сарын 18-ны УИХ-ын нэгдсэн чуулганаар Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж гишүүдийн 80.4 хувийн саналаар уг нэмэлт, өөрчлөлт батлагджээ. Нийт 150 орчим заалтад өөрчлөлт орсон ба өөрчлөлтийн гол онцлог нь банкууд охин компани байгуулах эрхгүй болж байгаа юм байна.

Монголд хууль журам дутагдсандаа бус хуулиа хэрэгжүүлэхгүй байгаадаа л хамаг учир байдаг. Өмнө нь Төв банкны Ерөнхийлөгч шийдвэрийг дангаар гаргадаг байсан бол одоо хамтын шийдэл болсон. 2010 онд СЗХ-оос 7 төрлийн зөвшөөрлийн дор арилжааны банк өөрөө охин компанитай байж болно гэдэг заалтыг хийсэн ба үүний үр дүнд иргэдийн мөнгийг зөвшөөрөлгүй зах зээлд эргэлдүүлэх боломжийг нээсний жишээ нь Эрдэнэтийн хөрөнгө оруулалт мөн 2 банкаар дамжуулж маш олон хуурамч компани байгуулсан. Худалдаа Хөгжлийн Банк гэхэд л Эрдэнэт, 3, 4-р станцууд, Багануурыг авахаар бүх ээлтгэлээ базаачихсан байна гэж Их хурлын гишүүн Ц.Нямдорж хэлсэн. Ихэнх улс төрчид барилгатай байх бөгөөд банкууд тэдгээр захирлуудтай холбоотой байж өөрсдийн барилгын охин компанитай байхаас гадна томоохон хувьцааг нь эзэмшиж байна. Муу зээл өглөө

гээд өөрсдөө компанийн үйл ажиллагаанд оролцож, үнийг бууруулахгүй барих гэх мэтээр чөлөөт өрсөлдөөнд саад болж байна.

Худалдаа Хөгжлийн Банкны 80 хувь ба Улаанбаатар Банкны 99 хувь нь Д.Эрдэнэбилэг гэдэг хүний нэр дээр байх ба тэр хүний байгуулсан янз бүрийн гадаад дотоодын компаниудаар дамжуулж эзэмшсэн байгаа юм. Худалдаа Хөгжлийн Банкны эзэн “National News Corporation” гэж компаниар дамжуулан Bloomberg Mongolia, Forbes сэтгүүл, “Засгийн газрын мэдээ” сониныг эзэмшиж байна. “Засгийн газрын мэдээ” сонины хувьд буруу агуулгатай нэртэй ба хүмүүст Засгийн газрын мэдээ хүргэж байгаа мэтээр төөрөгдүүлж байна. Голомт Банк “Монгол Масс Медиа” хэмээх группээр дамжуулж Ийгл, Боловсрол телевизийг эзэмшиж байна.

Ийнхүү хууль хэрэгжсэнээр энэ оны 12-р сарын 1-н гэхэд банкууд жижиг хараат ба охин компаниудаа хаах ёстой. Ингэснээр зах зээлийн чөлөөт өрсөлдөөн бий болоход урагшаа нэг алхах юм.

ТАВАНТОЛГОЙН ТӨМӨР ЗАМ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Ерөнхий сайд У.Хүрэлсүх мэдэгдэхдээ Тавантолгойн төмөр замын төслийг Хятадуудтай хамтарч хийнэ гэжээ.

Хятадын компаниуд чинь төмөр замаа ч эзэмшдэг, уул уурхайгаа ч эзэмшдэг ба Хятадтай хамтарч ажиллахын тулд тийм компанитай хамтрахаас өөр сонголтгүй боллоо гэдгийг бид сая ойлголоо. Бид өөрийнхөө төрийн компанитай ажиллахгүй, дээрээс нь хувьчилсан хэрнээ гадаадынхтай ажиллахгүй гэж хэсэг ярьсан. Хятадын хувьд тэр нь боломжгүй гэдгийг харж байна. Ер нь бид хэнтэй ч ажилласан гэсэн нүүрсээ Хятад руу л гаргана. Энэ бүхэн уул уурхайгаас өөр сонголт байхгүй, ба уул уурхай дундаа бидэнд нүүрс л байгаа юм гэдгийг ойлгуулж байна. Хятадууд дуртай үедээ хилээ хаагаад байгааг зогсоохын тулд тэдэнтэй хамтарч төмөр зам барихаас өөр сонголтгүй байна л даа. Гэхдээ барихдаа оруулсан хөрөнгийг нь нүүрсээр төлнө, нүүрсээр авахгүй бол авсанд тооцно гэдэг асуудал байх хэрэгтэй. Төр засаг маань төмөр зам барина л гэдэг хэн барих юм бэ? Дарга нарын компани нь барих юмуу, энгийн хувийн компаниуд барих юмуу? Үүн дээрээ л эвсэж чадахгүй байгаа болохоор өдийг хүргэлээ. Тэгэхээр яг төрийн өмчтэй компани хийх үү, төр өөр компани

байгуулах юмуу? Хэрэв ахиад нэг компани бий болговол хулгай хийхгүй байх нөхцлийг яаж хангах билээ. Яг хэн, яаж хянах вэ гэдэг механизмаа тодорхой байлгамаар байна. Энэ ярьж байгаа дарга нар ихэвчлэн 2 жилийн дараа алга болчихдог шүү дээ. Монголын Засгийн газар 18 сарын л настай байгаа. Нөгөө талаас Хятад төр нь өөрчлөгддөггүй, нэг хүн гарахаар 5,10 жил болдог. Ийм хүмүүстэй харьцаж байгаа учраас бид ул суурьтай байх хэрэгтэй байгаа юм.

Шинэ төмөр зам байгуулахад саад болдог бас нэг зүйл нь 1949 онд Улаанбаатар төмөр замыг байгуулсан гэрээ байдаг юм билээ. Үүнд 50:50 хувь байна, шинээр Монгол улсад төмөр зам барих бол Улаанбаатар төмөр замаар дамжуулж барина гэсэн гэрээ байдаг. Оросын тал энэ гэрээгээ хүчин төгөлдөр гэж үздэг юм байна. Уг нь энэ гэрээг байгуулсан субъект ЗХУ байхгүй болчихсон л доо. Оросоос шатахууны хувьд хараат учраас бид шаардлага тавьж чадахгүй байна. Тиймээс бид урд талаас Хятадтай хамт бариад хамт эзэмшээд, хойд талаас Оростой хамт бариад хамт эзэмшээд, бүгдийнх нь татварыг нэгдсэн нөхцөлд оруулж коридороо тавих хэрэгтэй.

ЖАГСААЛ ЦУГЛААН



Гэрэл зургийг [facebook.com](https://www.facebook.com)

Энэ 7 хоногт Утааны эсрэг ээж, аавууд ТББ-аас хэвтээ жагсаал зохион байгуулсан бол Үйлдвэрчний эвлэлээс татварын нэмэгдлийн эсрэг жагсаалыг зохион байгууллаа. Утааны эсрэг жагсаалд 100 орчим иргэн оролцсон. Харин татварын нэмэгдлийг 10 мянган орчим хүн эсэргүүцэн жагсжээ.

Ардчиллын гайхамшигтай зүйл нь би ингэж ярьж, та бид үзэл бодлоо илэрхийлж болдог, үнэн зүйлийн төлөө дуустлаа тэмцэж ялдагт оршдог. 10 мянган хүн гараад ирэхээр улс төрчид бас анхаарч байгаа гэж найдаж байна. ОУВС-ийн төлөөлөгчид ирэхээр энэ бол нэг аргумент болж байгаа юм. Үүнд арга хэмжээ авахгүй бол МАН сонгуулийн амлалтнаасаа буцсан асуудалд орно. Харин АН энэ асуудлыг өөрөө хийгээгүй юм шиг сайхан тоглож л байна. Энэ 2 намын хоорондын тоглоом шоглоомоор татвар нэмэгдэж, 100 тэрбум төгрөг зарцуулаад ч утаа нэмэгдээд байна гэдгийг бүгд харж байна.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh18-sh1-21> холбоосоор үзнэ үү



NEW NISSAN PATROL

☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84** сар

УРАМШУУЛАЛ:

Хамгаалтын хууца

Сэлбэг сервисын эрх

4x4 Өмчийн дугуй

Салонины шигшнэй хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette



Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонсүрэнгийн Билгүүн
Өсөхбаярын Биндэръяа
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn